

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ	2
2.	Аудитын тайлан	4
2.1.	Оршил	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3.	Менежментийн захидал	10
4.	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16
4.4	Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	18
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ М.ДАВААБАТ ТАНАА

2019.02.25 № 06/301
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн захирал М.Даваабат Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил болон аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 11-нээс 2019 оны 2 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 23-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Энич Аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Энич Аудит ХХК-д 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 41 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төв нь Орчин үеийн дэвшилтэт технологийг үе шаттай нэвтрүүлж, хөдөлмөрийн нөхцөлийг судлах, үнэлэх, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс сэргийлэх, оношлох, эмчлэх, нөхөн сэргээх үйлчилгээг олон улсын стандартын шаардлагад нийцүүлэх эрдэм шинжилгээ, сургалт, судалгаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй байдлыг сайжруулж, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бууруулах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/169 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн дүрэм”-ээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг судлах, эрүүл ахуйн хэмжилт хийх, үнэлгээ, дүгнэлт гаргах
- Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг оношлох, эрт илрүүлэх, эмчлэх, нөхөн сэргээж сувилах
- Хөдөлмөр зохицуулалт, магадлал хийх
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон сурталчилгааны ажлыг зохион байгуулах

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн

байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төв санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 2 хувиар сонгов.

Байгууллагын үндсэн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг баталсан төсвийн дагуу хэрэгжүүлдэг төсвийн байгууллага тул материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгох нь зохимжтой гэж үзэв.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,894,347.3 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 37,886.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь хэрэгжүүлсэн горим сорилын үр дүн, нөхцөл байдлыг харгалзаж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	1,250.0	/мянган төгрөгөөр/
2	Албан шаардлага өгсөн	2	35,543.3	
	Дүн	3	36,793.3	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

2010-2015 онд үүссэн 14 харилцагчийн 31,651.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй.

Энэ нь үнэлгээ, үнэн зөв байдал, эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

2. Зардлын данстай холбоотой асуудал

Нэр бүхий 6 ажилтанд 3,891.5 мянган төгрөгийн цалин, ээлжийн амралт давхардуулан олгосон.

Энэ нь үнэн зөв байдал, хэмжилт, тохиолдсон байх батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-д "Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. ...", мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг төвийн захирлын 2018 оны А/56 тоот тушаалаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 8.8-д "Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийг үндэслэн ажилтанд жил бүр ээлжийн амралтыг олгож биеэр эдлүүлэх ..." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тайлант хугацаанд туслах үйл ажиллагаанаас 171,000.0 мянган төгрөгийн орлого олохоор төлөвлөж, гүйцэтгэл 12.0 хувийн биелэлттэй буюу 20,051.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг бүрдүүлдэг Агаар сувиллын үйл ажиллагаа хаагдсанаас 2016-2018 онд туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 11.0-12.0 хувийн биелэлттэй байна.

Агаар сувиллын барилга нь эрүүл ахуйн болон аюулгүйн шаардлагыг хангахгүй болсон тухай Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2014 оны 02-07-90/604 тоот дүгнэлт болон сувиллыг цаашид засварлах болон шинэ барилга байгууламж барьж үйл ажиллагааг явуулах шаардлагатай байгаа тухай тайлбар, тодруулгыг аудитын явцад 2019 оны 78 тоот албан бичгээр Энич Аудит ХХК-д ирүүлсэн.

Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв нь Мэргэжлээс шалтгаалах өвчин судлалын эмнэлэг, Агаар сувиллын барилгууд нь эрүүл ахуйн болон аюулгүйн шаардлагыг хангахгүй болсон, лабораторийн барилга нь 2016 онд ашиглалтанд орсон тул эдгээр барилга байгууламжийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийлгээгүй талаар тайлбарыг 2019 оны 77 тоот албан бичгээр Энич Аудит ХХК-д ирүүлсэн.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 41 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1,749,002.5 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,621,784.2 мянган төгрөг буюу 92.7 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж болон нормативт зардлын хэмнэлтээс шалтгаалжээ.

Тайлант хугацаанд дээд шатны төсвийн захирагчаас 126,578.6 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч бараа, ажил үйлчилгээний зардалд зарцуулсан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 73.3 хувьтай байна.

Туслах үйл ажиллагааны орлогыг бүрдүүлдэг Агаар сувилал ажиллах боломжгүйгээс өмнөх аудитаар өгөгдсөн 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Томилолтын зардлын анхан шатны баримтын бүрдэл дутуу, албан томилолтын хуудсыг баталгаажуулаагүй 1,250.0 мянган төгрөгийг зарцуулсан.

Энэ нь үнэн зөв байдал, хэмжилт, тохиолдсон байх батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", мөн Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 3 дугаар зүйлийн "Зардлыг хүлээн зөвшөөрөх ба үнэлэх" хэсэгт "Төсвийн зардлыг батлагдсан төсөв, зарцуулалтын эрхийн баталгаа, эрх бүхий байгууллагын шийдвэр, гэрээг үндэслэж гарсан зардлыг анхан шатны баримтыг үндэслэн хүлээн зөвшөөрч бүртгэнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

1.2. Эрсдэл:

Төсвийг хэмнэлтгүй зарцуулах, зардал өсөх болон санхүүгийн үр дүн буурах

1.3. Өгсөн зөвлөмж:

Томилолтын зардлыг анхан шатны баримтыг үндэслэн хүлээн зөвшөөрч бүртгэх

1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг байгууллагын дарга, нягтлан бодогч нар хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	283,605,051.98	545,185,740.16
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	83.20	83.20
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	83.20	83.20
3121	Төгрөг	83.20	83.20
31213	Арилжааны банк дахь харилцах	83.20	83.20
33	АВЛАГА	119,146,104.72	263,778,584.36
335	Бусад авлага	106,035,050.62	250,130,099.26
3351	Байгууллагаас авах авлага	100,864,046.62	244,959,095.26
3352	Хувь хүмүүсээс авах авлага	5,171,004.00	5,171,004.00
35	БАРАА МАТЕРИАЛ	164,458,864.06	281,407,072.60
351	Түүхий эд материал	72,426,148.32	166,991,094.86
35130	Эм боох материал	72,426,148.32	166,991,094.86
354	Хангамжийн материал	92,032,715.74	114,415,977.74
35410	Бичиг хэргийн материал	4,631,235.00	13,642,815.00
35420	Аж ахуйн материал	28,785,435.00	27,836,935.00
35430	Сэлбэг хэрэгсэл	9,421,800.00	11,919,800.00
35470	Бусад хангамжийн материал	49,194,245.74	61,016,427.74
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,749,930,647.65	2,682,159,794.07
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,749,930,647.65	2,682,159,794.07
392	Биет хөрөнгө	2,643,088,981.00	2,553,534,807.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,039,461,171.00	3,039,461,171.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-868,716,103.74	-937,867,333.88
39203	Авто-тээврийн хэрэгсэл	176,900,000.00	176,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-115,062,499.80	-144,545,833.08
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	890,555,199.44	1,000,370,799.44
39206	Хуримтлагдсан элэгдэл	-559,185,220.40	-655,051,757.18
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	155,492,871.52	164,308,871.52
39208	Хуримтлагдсан элэгдэл	-78,603,587.02	-92,189,260.40
39214	Бусад үндсэн хөрөнгө	990,000.00	990,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-206,250.00	-305,250.00
39217	Ном	1,463,400.00	1,463,400.00
393	Биет бус хөрөнгө	106,841,666.65	128,624,986.65
39301	Програм хангамж	131,220,000.00	131,220,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-24,378,333.35	-50,478,333.35
39303	Бусад биет бус хөрөнгө		47,883,320.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,033,535,699.63	3,227,345,534.23
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	259,644,523.98	259,491,028.91
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	259,644,523.98	259,491,028.91
413	Өглөг	251,980,523.98	246,390,228.91
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	33,084,959.58	15,934,032.59
4136	Бусад өглөг	218,895,564.40	230,456,196.32
41361	Байгууллагад төлөх өглөг	218,805,564.40	229,983,035.32
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	90,000.00	473,161.00
414	Урьдчилж орсон орлого	7,664,000.00	13,100,800.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	7,664,000.00	13,100,800.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,773,891,175.65	2,967,854,505.32
51	Засгийн газрын хувь оролцоо	2,773,891,175.65	2,967,854,505.32
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	642,467,060.90	690,350,380.90
51101	Өмч: - төрийн	642,467,060.90	642,467,060.90
512	Хуримтлагдсан үр дүн	2,131,424,114.75	2,277,504,124.42
51210	Өмнөх үеийн үр дүн	159,821,854.72	2,131,424,114.75
51220	Тайлант үеийн үр дүн	1,971,602,260.03	147,539,059.67
51300	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		-1,459,050.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,033,535,699.63	3,227,345,534.23

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,762,994,341.00	2,041,886,378.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,559,955,441.00	987,133,378.20
120	Нийтлэг татварын бус орлого	2,559,955,441.00	978,923,518.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,559,955,441.00	978,923,518.20
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	539,420,481.00	858,710,754.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,534,960.00	21,212,764.20
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,000,000,000.00	99,000,000.00
122	Тусламжийн орлого	-	8,209,860.00
122001	Хандив тусламж /дотоод/		8,209,860.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,203,038,900.00	1,054,753,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,054,095,900.00	928,002,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,054,095,900.00	928,002,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	148,943,000.00	126,750,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	148,943,000.00	126,750,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,791,392,080.96	1,894,347,318.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,704,464,237.25	1,809,840,454.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,704,464,237.25	1,809,840,454.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	880,974,133.00	893,161,604.00
210101	Үндсэн цалин	880,974,133.00	893,161,604.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,330,113.06	108,803,285.42
210201	Тэтгэврийн даатгал	65,388,807.02	73,467,372.98
210202	Тэтгэмжийн даатгал	8,002,226.86	8,833,976.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,295,734.49	7,067,182.09
210204	Ажилгүйдлийн даатгал	2,190,062.15	1,766,795.02
210205	Эрүүл мэндийн даатгал	17,453,282.54	17,667,959.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,624,162.00	33,680,353.00
210301	Гэрэл, цахилгаан	6,449,047.00	8,308,709.00
210302	Түлш, халаалт	7,994,743.00	14,601,096.00
210303	Цэвэр, бохир ус	3,580,372.00	10,410,548.00
210304	Байрны түрээс	1,600,000.00	360,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	80,516,739.28	99,664,160.00
210401	Бичиг хэрэг	22,131,580.00	31,381,620.00
210402	Тээвэр, шатахуун	13,806,500.00	22,407,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,854,119.28	9,256,350.00
210404	Ном, хэвлэл	19,220,000.00	11,459,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,397,000.00	3,583,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,107,540.00	21,576,090.00

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	271,865,867.88	266,666,341.98
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	271,865,867.88	254,584,132.98
210502	Хоол, хүнс		11,097,209.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		985,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,384,295.00	18,538,152.00
210604	Урсгал засвар	12,384,295.00	18,538,152.00
2107	Томилолт, зочны зардал	28,069,870.00	40,352,463.00
210702	Дотоод албан томилолт	28,069,870.00	40,352,463.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	101,697,397.00	97,041,122.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,083,697.00	57,084,480.00
210803	Даатгалын үйлчилгээ		143,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	315,900.00	92,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	24,700.00	3,400,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	990,000.00	33,056,000.00
210807	Газрын төлбөр	283,100.00	1,465,442.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		1,800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	209,001,660.03	251,932,973.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	675,000.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	800,000.00	17,647,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	207,526,660.03	234,285,773.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,927,843.71	84,506,863.55
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	16,563,970.72	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	16,563,970.72	
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,363,872.99	41,858,950.44
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	900,472.99	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,123,900.00	28,358,950.44
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	44,339,500.00	13,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	42,647,913.11
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		42,647,913.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,971,602,260.04</u>	<u>147,539,059.67</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,971,602,260.04</u>	<u>147,539,059.67</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,754,871,233.00</u>	<u>1,791,010,794.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	551,832,333.00	736,153,794.00
120	Нийтлэг татварын бус орлого	551,832,333.00	736,153,794.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	551,832,333.00	736,153,794.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	532,798,961.00	716,102,794.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,033,372.00	20,051,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,203,038,900.00	1,054,857,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,054,095,900.00	928,106,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,054,095,900.00	928,002,500.00
300001	НДЗ орлого		104,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	148,943,000.00	126,750,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	148,943,000.00	126,750,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,703,532,233.00</u>	<u>1,779,554,794.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,703,532,233.00	1,779,554,794.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,616,304,862.28	1,695,047,930.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	937,569,000.00	907,837,586.00
210101	Үндсэн цалин	733,260,400.00	669,947,986.00
210102	Нэмэгдэл	126,737,000.00	160,318,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	77,571,600.00	77,571,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	157,487,800.00	104,007,260.05
210201	Тэтгэврийн даатгал	157,487,800.00	104,007,260.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,624,162.00	33,680,353.00
210301	Гэрэл, цахилгаан	6,449,047.00	8,308,709.00
210302	Түлш, халаалт	7,994,743.00	14,601,096.00
210303	Цэвэр, бохир ус	3,580,372.00	10,410,548.00
210304	Байрны түрээс	1,600,000.00	360,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	70,165,719.28	96,050,550.00
210401	Бичиг хэрэг	16,879,500.00	29,877,100.00
210402	Тээвэр, шатахуун	12,543,500.00	22,407,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,854,119.28	9,256,350.00
210404	Ном, хэвлэл	19,220,000.00	11,459,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,523,600.00	3,583,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,145,000.00	19,467,000.00
2105	Нормативт зардал	260,408,919.00	340,302,405.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	260,008,919.00	327,715,196.40
210502	Хоол, хүнс		11,097,209.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,000.00	1,490,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,676,795.00	37,337,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,760,200.00	14,339,248.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		801,400.00

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	16,916,595.00	22,196,652.00
2107	Томилолт, зочны зардал	28,069,870.00	40,352,463.00
210702	Дотоод албан томилолт	28,069,870.00	40,352,463.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	118,502,597.00	117,832,813.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	116,888,897.00	63,636,171.00
210803	Даатгалын үйлчилгээ		143,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	315,900.00	92,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	24,700.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	990,000.00	36,456,000.00
210807	Газрын төлбөр	283,100.00	1,465,442.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		16,040,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	800,000.00	17,647,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	800,000.00	17,647,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	87,227,370.72	84,506,863.55
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	16,563,970.72	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	16,563,970.72	
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,663,400.00	41,858,950.44
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,123,900.00	28,358,950.44
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	45,539,500.00	13,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	42,647,913.11
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		42,647,913.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>51,339,000.00</u>	<u>11,456,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	51,339,000.00	11,456,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	51,339,000.00	11,456,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	51,339,000.00	11,456,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	51,339,000.00	11,456,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-51,339,000.00</u>	<u>-11,456,000.00</u>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	83.20	83.20
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	83.20	83.20

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	642,467,060.90	503,559,860.73	1,146,026,921.63
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-36,013,035.48	-36,013,035.48
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	642,467,060.90	467,546,825.25	1,110,013,886.15
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			-
C07	Тайлант үеийн үр дүн		-276,101,171.55	-276,101,171.55
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	642,467,060.90	2,131,424,114.75	2,773,891,175.65
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-1,459,050.00	-1,459,050.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	642,467,060.90	2,129,965,064.75	2,772,432,125.65
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	47,883,320.00		47,883,320.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			-
D08	Тайлант үеийн үр дүн		147,539,059.67	147,539,059.67
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	690,350,380.90	2,277,504,124.42	2,967,854,505.32

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,749,002,500.00	1,621,784,271.89	-127,218,228.11	92.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,749,002,500.00	1,621,784,271.89	-127,218,228.11	92.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,715,418,300.00	1,593,425,321.45	-121,992,978.55	92.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	918,957,000.00	907,837,586.00	-11,119,414.00	98.8
210101	Үндсэн цалин	681,067,400.00	669,947,986.00	-11,119,414.00	98.4
210102	Нэмэгдэл	160,318,000.00	160,318,000.00	-	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	77,571,600.00	77,571,600.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,244,900.00	104,007,260.05	-2,237,639.95	97.9
210201	Тэтгэврийн даатгал	106,244,900.00	104,007,260.05	-2,237,639.95	97.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,636,600.00	33,320,353.00	-11,316,247.00	74.6
210301	Гэрэл, цахилгаан	14,506,300.00	8,308,709.00	-6,197,591.00	57.3
210302	Түлш, халаалт	19,063,000.00	14,601,096.00	-4,461,904.00	76.6
210303	Цэвэр, бохир ус	11,067,300.00	10,410,548.00	-656,752.00	94.1
210304	Байрны түрээс			-	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	76,400,000.00	75,566,150.00	-833,850.00	98.9
210401	Бичиг хэрэг	25,578,700.00	25,578,700.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	18,957,300.00	18,957,300.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,450,000.00	8,942,350.00	-507,650.00	94.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,910,000.00	3,583,800.00	-326,200.00	91.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,504,000.00	18,504,000.00	-	100.0
2105	Нормативт зардал	388,573,200.00	329,205,196.40	-59,368,003.60	84.7
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	384,576,200.00	327,715,196.40	-56,861,003.60	85.2
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,997,000.00	1,490,000.00	-2,507,000.00	37.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,383,000.00	45,343,300.00	-1,039,700.00	97.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	23,322,000.00	22,345,248.00	-976,752.00	95.8
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	783,000.00	801,400.00	18,400.00	102.3
210604	Урсгал засвар	22,278,000.00	22,196,652.00	-81,348.00	99.6
2107	Томилолт, зочны зардал	43,867,800.00	39,358,463.00	-4,509,337.00	89.7

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	43,867,800.00	39,358,463.00	-4,509,337.00	89.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	90,355,800.00	58,787,013.00	-31,568,787.00	65.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	69,933,700.00	41,046,371.00	-28,887,329.00	58.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000.00		-1,485,000.00	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	653,900.00	143,100.00	-510,800.00	21.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	694,000.00	92,100.00	-601,900.00	13.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00		-40,000.00	0.0
210807	Газрын төлбөр	1,509,200.00	1,465,442.00	-43,758.00	97.1
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	16,040,000.00	16,040,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,584,200.00	28,358,950.44	-5,225,249.56	84.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,584,200.00	28,358,950.44	-5,225,249.56	84.4
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,584,200.00	28,358,950.44	-5,225,249.56	84.4
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл			-	0.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,749,002,500.00	1,621,784,271.89	-127,218,228.11	92.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	928,002,500.00	885,630,477.89	-42,372,022.11	95.4
131001	Улсын төсвөөс санхүүжих	928,002,500.00	885,630,477.89	-42,372,022.11	95.4
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	821,000,000.00	736,153,794.00	-84,846,206.00	89.7
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	650,000,000.00	716,102,794.00	66,102,794.00	110.2
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	171,000,000.00	20,051,000.00	-150,949,000.00	11.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	96	96		
620001	Удирдах ажилтан	2	2		
620002	Гүйцэтгэх ажилтан	59	59		
620003	Үйлчлэх ажилтан	35	35		
620004	Гэрээт ажилтан				

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	126,578,609.00	126,578,609.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	126,578,609.00	126,578,609.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	113,078,609.00	113,078,609.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	360,000.00	360,000.00
210304	Байрны түрээс	360,000.00	360,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,484,400.00	20,484,400.00
210401	Бичиг хэрэг	4,298,400.00	4,298,400.00
210402	Тээвэр, шатахуун	3,450,000.00	3,450,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	314,000.00	314,000.00
210404	Ном, хэвлэл	11,459,000.00	11,459,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	963,000.00	963,000.00
2105	Нормативт зардал	11,097,209.00	11,097,209.00
210502	Хоол, хүнс	11,097,209.00	11,097,209.00
2107	Томилолт, зочны зардал	994,000.00	994,000.00
210702	Дотоод албан томилолт	994,000.00	994,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	62,495,800.00	62,495,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,039,800.00	26,039,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	36,456,000.00	36,456,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,647,200.00	17,647,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,647,200.00	17,647,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,500,000.00	13,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,500,000.00	13,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,500,000.00	13,500,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	126,578,609.00	126,578,609.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	126,578,609.00	126,578,609.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	126,578,609.00	126,578,609.00

5. Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/САГ-2019/66/СТА-ТШЗ/	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Энич Аудит ХХК	Аудит хийсэн баг, албан тушаалтан
		Н.Наран

Хоёр Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

(мянган төгрөгөөр)

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн		Үүнээс			
		Тоо	Дүн	Зөвлөмж	Төлбөрийн акт	Албан шаардлага	Хууль хяналтын бусад байгууллагад шилжүүлсэн
А	1	2	3	4	5	6	7
1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв	3	36,793.3	1,250.0		35,543.3	
	ДҮН	3	36,793.3	1,250.0		35,543.3	

2.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ач холбогдлоор нь эрэмбэлж танилцуулах:

Алдаа, зөрчилтэй асуудал 1

2010-2015 онд үүссэн, 14 харилцагчийн 31,651.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөх

Алдаа, зөрчилтэй асуудал 2

Нэр бүхий 6 ажилтанд 3,891.5 мянган төгрөгийн цалин, ээлжийн амралт давхардуулан олгосон. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-д "Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. ...", мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг төвийн захирлын 2018 оны А/56 тоот тушаалаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 8.8-д "Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийг үндэслэн ажилтанд жил бүр ээлжийн амралтыг олгож биеэр эдлүүлэх ..." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөх

Алдаа, зөрчилтэй асуудал 3

Томилолтын зардлын анхан шатны баримтын бүрдэл дутуу, албан томилолтын хуудсыг баталгаажуулаагүй 1,250.0 мянган төгрөгийг зарцуулсан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", мөн Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 3 дугаар зүйлийн "Зардлыг хүлээн зөвшөөрөх ба хэмжих" хэсэгт "Төсвийн зардлыг батлагдсан төсөв, зарцуулалтын эрхийн баталгаа, эрх бүхий байгууллагын шийдвэр, гэрээг үндэслэж гарсан зардлыг анхан шатны баримтыг үндэслэн хүлээн зөвшөөрч бүртгэнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Томилолтын зардлыг анхан шатны баримтыг үндэслэн хүлээн зөвшөөрч бүртгэх талаар зөвлөмж өгөх

2.2 Аудитын санал дүгнэлтийн үндэслэл:

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

